**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/209/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024.02.23 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: Azbayar@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 13

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 17

**4.1 Ерөнхий зүйл** ..... 17

**4.2 Материаллаг байдал** ..... 17

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 17

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 17

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 18

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 18

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 18

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 19

**5.1 Төлбөрийн акт** ..... 19

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 20


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/17

танай__________-ны № __________ -т

БАЯНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЦЭНД-АЮУШ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Шинэ жилийн баярыг тохиолдуулан бараа үйлчилгээний бусад зардлаас 4,000.0 мянган төгрөгөөр ахмад настан болон байгууллагын шилдэг ажилчдад бэлэг гардуулсан нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй.

5020100

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **80,341,262.27** | **200,925,896.28** |
| **33** | **АВЛАГА** | 425,229.24 | 15,107,904.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 425,229.24 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 15,107,904.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 79,916,033.03 | 185,817,992.28 |
| **351** | **Түүхий эд материал** | 54,023,225.00 | 151,044,486.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 54,023,225.00 | 151,044,486.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 25,892,808.03 | 34,773,506.28 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 960,000.00 | 702,730.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,569,780.00 | 6,857,280.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 310,000.00 | 2,724,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 3,200,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,053,028.03 | 21,289,496.28 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **909,246,371.79** | **1,145,224,754.76** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 909,246,371.79 | 1,145,224,754.76 |
| **392** | **Биет хөрөнгө** | 860,650,171.79 | 1,086,600,554.76 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 800,356,683.00 | 820,356,683.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -237,160,568.82 | -268,573,987.50 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 180,114,800.00 | 295,704,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -122,824,561.64 | -135,270,871.16 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 240,820,511.00 | 147,321,011.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -176,967,476.97 | -96,200,211.89 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 52,276,210.50 | 57,626,210.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -34,288,626.97 | -38,110,376.89 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 231,399,549.00 | 388,403,791.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -73,076,347.31 | -84,656,493.30 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 48,596,200.00 | 58,624,200.00 |
| 39301 | Програм хангамж | 5,510,000.00 | 5,510,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -230,000.00 | -1,286,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 43,316,200.00 | 54,400,200.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **989,587,634.06** | **1,346,150,651.04** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,865,476.00** | **10,000,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,865,476.00 | 10,000,000.00 |
| **413** | **Өглөг** | 1,865,476.00 | 10,000,000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,748,676.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 116,800.00 | 10,000,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 116,800.00 | 10,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **987,722,158.06** | **1,336,150,651.04** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 987,722,158.06 | 1,336,150,651.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 302,128,037.00 | 302,128,037.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 302,128,037.00 | 302,128,037.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 670,028,225.10 | 1,018,456,718.08 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 670,028,225.10 | 670,028,225.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 348,428,492.98 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 15,565,895.96 | 15,565,895.96 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **989,587,634.06** | **1,346,150,651.04** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **628,914,931.00** | **1,163,620,739.25** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **199,114,781.00** | **382,654,576.25** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,000,000.00 | 1,083,990.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,000,000.00 | 1,080,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,080,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 3,990.00 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 198,114,781.00 | 381,570,586.25 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **429,800,150.00** | **780,966,163.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 35,762,008.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 35,762,008.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,050,000.00 | 52,957,763.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 6,323,261.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,050,000.00 | 46,634,502.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 392,988,142.00 | 728,008,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 392,988,142.00 | 728,008,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **482,793,079.06** | **815,192,246.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **482,793,079.06** | **815,192,246.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 460,968,810.30 | 732,682,710.80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 231,484,460.00 | 380,582,727.84 |
| 210101 | Үндсэн цалин | 231,484,460.00 | 281,695,482.84 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 62,338,525.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 8,580,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 26,683,720.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 1,285,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,417,238.00 | 47,315,235.38 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,417,238.00 | 34,064,454.66 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 3,355,996.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 2,684,796.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 655,451.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 6,554,535.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,637,876.00 | 27,909,439.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,812,965.00 | 5,818,937.55 |
| 210302 | Түлш, халаалт | 21,824,911.00 | 21,621,002.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 469,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,471,645.00 | 33,384,609.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,280,900.00 | 3,467,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,186,845.00 | 27,561,059.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 75,000.00 | 855,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 146,400.00 | 573,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 782,500.00 | 927,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 220,000.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 220,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 185,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 185,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,732,000.00 | 6,810,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,732,000.00 | 6,810,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,939,745.00 | 51,090,422.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,379,505.00 | 47,633,970.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 324,240.00 | 310,452.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 172,000.00 | 176,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 2,970,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 114,065,846.30 | 185,405,277.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,540,750.00 | 105,058,218.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 240,000.00 | 2,952,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,285,096.30 | 77,394,759.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21,824,268.76 | 82,509,535.47 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,757,242.00 | 59,045,300.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 43,059,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,313,242.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 14,585,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,444,000.00 | 1,400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,239,502.00 | 00.00 |
| 213304 | Хөрөнгийн | 9,239,502.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,827,524.76 | 23,464,235.47 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,827,524.76 | 23,464,235.47 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **146,121,851.94** | **348,428,492.98** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **146,121,851.94** | **348,428,492.98** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **430,800,150.00** | **782,050,153.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,000,000.00** | **1,083,990.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,000,000.00 | 1,083,990.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,000,000.00 | 1,080,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,080,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 3,990.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **429,800,150.00** | **780,966,163.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 35,762,008.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 35,762,008.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,050,000.00 | 52,957,763.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 6,323,261.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,050,000.00 | 46,634,502.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 392,988,142.00 | 728,008,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 392,988,142.00 | 728,008,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **418,502,150.00** | **727,325,253.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **418,502,150.00** | **727,325,253.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **396,721,881.24** | **629,707,813.53** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 220,872,459.24 | 373,809,371.98 |
| 210101 | Үндсэн цалин | 209,872,459.24 | 226,805,199.94 |
| 210102 | Нэмэгдэл | 11,000,000.00 | 99,291,645.76 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 8,580,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 24,243,221.78 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 14,889,304.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,106,600.00 | 47,124,594.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,431,700.00 | 32,037,944.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,168,800.00 | 3,770,987.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,735,000.00 | 3,017,570.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 433,700.00 | 753,718.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,337,400.00 | 7,544,375.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,083,426.00 | 27,726,402.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,812,965.00 | 5,635,900.10 |
| 210302 | Түлш, халаалт | 20,270,461.00 | 21,621,002.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 469,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,473,765.00 | 33,068,440.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,217,300.00 | 2,915,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,271,465.00 | 22,635,580.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 285,000.00 | 730,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 700,000.00 | 510,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,000,000.00 | 5,507,010.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 770,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 2,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 2,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,732,000.00 | 6,810,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,732,000.00 | 6,810,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 37,017,451.00 | 93,173,665.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 32,457,211.00 | 89,568,265.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 324,240.00 | 338,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 172,000.00 | 172,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,095,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 50,436,180.00 | 45,395,340.45 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,955,180.00 | 40,067,040.45 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 481,000.00 | 5,328,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28134053.52** | **77144278.94** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,067,026.76 | 38,572,139.47 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 43,059,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,313,242.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 14,585,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,400,000.00 | 1,400,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 14,067,026.76 | 38,572,139.47 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,827,524.76 | 23,464,235.47 |
| 213404 | Хөрөнгийн | 9,239,502.00 | 15,107,904.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **12,298,000.00** | **54,724,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **12,298,000.00** | **54,724,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,298,000.00** | **54,724,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,298,000.00 | 54,724,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 12,298,000.00 | 54,724,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-12,298,000.00** | **-54,724,900.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 302,128,037.00 | 17,485,895.96 | 278,906,861.48 | 00.00 | 598,520,794.44 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **302,128,037.00** | **17,485,895.96** | **278,906,861.48** | **00.00** | 598,520,794.44 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 54,435,883.31 | 00.00 | 54,435,883.31 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **302,128,037.00** | **15,565,895.96** | **670,028,225.10** | **00.00** | 987,722,158.06 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **302,128,037.00** | **15,565,895.96** | **670,028,225.10** | **00.00** | 987,722,158.06 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **302,128,037.00** | **15,565,895.96** | **670,028,225.10** | **00.00** | 987,722,158.06 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 348,428,492.98 | 00.00 | 348,428,492.98 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **302,128,037.00** | **15,565,895.96** | **1,018,456,718.08** | **00.00** | 1,336,150,651.04 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 729,008,300.00 | 705,628,154.53 | 23,380,145.47 | 96.79 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 729,008,300.00 | 705,628,154.53 | 23,380,145.47 | 96.79 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 669,963,000.00 | 646,582,854.53 | 23,380,145.47 | 96.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 377,252,200.00 | 373,809,371.98 | 3,442,828.02 | 99.09 |
| 210101 | Үндсэн цалин | 247,927,600.00 | 226,805,199.94 | 21,122,400.06 | 91.48 |
| 210102 | Нэмэгдэл | 107,724,600.00 | 99,291,645.76 | 8,432,954.24 | 92.17 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 8,580,000.00 | -8,580,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 24,243,221.78 | -24,243,221.78 | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,600,000.00 | 14,889,304.50 | 6,710,695.50 | 68.93 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,156,600.00 | 47,124,594.00 | 32,006.00 | 99.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,066,500.00 | 32,037,944.00 | 28,556.00 | 99.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,772,500.00 | 3,770,987.00 | 1,513.00 | 99.96 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,018,000.00 | 3,017,570.00 | 430.00 | 99.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 754,500.00 | 753,718.00 | 782.00 | 99.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,545,100.00 | 7,544,375.00 | 725.00 | 99.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,052,900.00 | 27,726,402.10 | 2,326,497.90 | 92.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,612,600.00 | 5,635,900.10 | -23,300.10 | 100.42 |
| 210302 | Түлш, халаалт | 23,440,300.00 | 21,621,002.00 | 1,819,298.00 | 92.24 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 469,500.00 | 530,500.00 | 46.95 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,695,800.00 | 35,668,440.00 | 8,027,360.00 | 81.63 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,859,100.00 | 5,515,650.00 | 343,450.00 | 94.14 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,126,400.00 | 22,635,580.00 | 1,490,820.00 | 93.82 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,300,300.00 | 730,200.00 | 570,100.00 | 56.16 |
| 210404 | Ном, хэвлэл | 510,000.00 | 510,000.00 | 0.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,060,000.00 | 5,507,010.00 | 5,552,990.00 | 49.79 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 840,000.00 | 770,000.00 | 70,000.00 | 91.67 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,600,000.00 | 12,600,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,600,000.00 | 12,600,000.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,695,700.00 | 6,810,000.00 | 2,885,700.00 | 70.24 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,695,700.00 | 6,810,000.00 | 2,885,700.00 | 70.24 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 97,824,000.00 | 92,198,706.00 | 5,625,294.00 | 94.25 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 93,500,000.00 | 88,593,306.00 | 4,906,694.00 | 94.75 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 | 500,000.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 338,000.00 | 338,000.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 172,000.00 | 172,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,314,000.00 | 3,095,400.00 | 218,600.00 | 93.40 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 51686000.00 | 50645340.45 | 1,040,659.55 | 97.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,686,000.00 | 45,317,040.45 | 368,959.55 | 99.19 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,000,000.00 | 5,328,300.00 | 671,700.00 | 88.81 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 59045300.00 | 59045300.00 | 0.00 | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 59,045,300.00 | 59,045,300.00 | 0.00 | 100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 43,059,700.00 | 43,059,700.00 | 0.00 | 100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14,585,600.00 | 14,585,600.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,400,000.00 | 1,400,000.00 | 0.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 729,008,300.00 | 705,628,154.53 | 23,380,145.47 | 96.79 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 728,008,300.00 | 704,708,154.53 | 23,300,145.47 | 96.80 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 728,008,300.00 | 704,708,154.53 | 23,300,145.47 | 96.80 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 28.00 | 28.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 03.00 | 03.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 21.00 | 21.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **37,849,859.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **37,849,859.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 37,849,859.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 37,849,859.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 37,849,859.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | **37,849,859.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | **37,849,859.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 6,323,261.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 31,526,598.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

• Төрийн үйлчилгээг хүлээж биш хүрч үйлчлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянбулаг сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 356,563.0 мянган төгрөг буюу 36.0 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 80,341.3 | 200,925.9 | 120,584.6 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 425.2 | 15,107.9 | 14,682.7 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 79,916.0 | 185,818.0 | 105,902.0 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 909,246.4 | 1,145,224.8 | 235,978.4 |
| Үндсэн хөрөнгө | 1,553,794.0 | 1,769,322.7 | 215,528.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (644,547.6) | (624,097.9) | 20,449.6 |
| **Нийт хөрөнгө** | 989,587.6 | 1,346,150.7 | 356,563.0 |
| Өр төлбөр | 1,865.5 | 10,000.0 | 8,134.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 987,722.2 | 1,336,150.7 | 348,428.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 989,587.6 | 1,346,150.7 | 356,563.0 |

Авлагын дансны үлдэгдэл 15,107.9 мянган төгрөг байгаа нь нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлсэн мөнгийг санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 185,818.0 мянган төгрөг болж 105,902.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 102,944.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, Онцгой байдлын газраас 30,832.0 мянган төгрөгийн өвс, хивэг, урьдчилан сэргийлэх багц, ХХААГ-аас 149.6 мянган төгрөгийн мал жинлэгч болон таяган болон туузан метр, Улсын төсвийн хөрөнгөөр 96,212.7 мянган төгрөгөөр 400 толгой хонь, сарлагийн 1 бухан бяруу, Сэлэнгэ үүлдрийн бухан бяруу 1 толгой бухан бяруу, 1 хуц, зэрэг нийт нийт 163,754.3 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 160,797.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,769,322.7 мянган төгрөг болж 215,528.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 64,724.9 мянга, үнэ төлбөргүй Универсал трактор 112,800.0 мянга, УТХО-аар багийн засаг дарга нарт 2,790.0 мянга, 11,084.0 мянган төгрөгийн 5 газар, 121,974.2 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авсантай холбоотой байна.

Мөн тайлант онд аймгийн Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр 97,844.4 мянган төгрөгийн балансын үнэ бүхий моторыг акталсан байна.

Нийт өр төлбөр 10,000.0 мянган төгрөг байгаа нь халаалтын засварыг 20,000.0 мянган төгрөгөөр хийсэн бөгөөд гүйцэтгэгч Елбата ХХК-д 2023.02.16-ны өдөр 10,000.0 төгрөгийг шилжүүлэн 10,000.0 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,336,150.7 мянган төгрөг болж 348,428.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 348,428.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 626,478.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 626,478.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 107,746.9 мянган төгрөгөөр бууруулж 518,731.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 729,008.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 705,628.2 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 23,380.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 705,628.2 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь Цалингийн зардал 3,442.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,326.5 мянга, хангамж, бараа материалын зардал 8,027.4 мянга, томилолтын зардал 2,885.7 бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 5,625.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,040.7 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 464,485.60 | 455,737.83 | 8.75 | 98.1 |
| 2 | 80106 Баг, хорооны ҮАЗардал | 75,815.40 | 71,470.75 | 4.34 | 94.3 |
| 3 | 80305 Биеийн тамирын уралдаан тэмцээн | 3,000.00 | 2,890.00 | 0.11 | 96.3 |
| 4 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 58,645.30 | 58,645.30 | 0.00 | 100.0 |
| 5 | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 32,362.00 | 32,109.62 | 0.25 | 99.2 |
| 6 | 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 84,000.00 | 79,267.65 | 4.73 | 94.4 |
| 7 | 82212 Хур хог хаягдал, орчны бохирдол | 10,700.00 | 5,507.01 | 5.19 | 51.5 |
| | НИЙТ | 729,008.30 | 705,628.15 | 23.38 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд мал тооллогын зардалд 535.3 мянга, Оготно устгалтын зардалд 4,000.0 мянга, “Хамтдаа шийдье” аян зохион байгуулах зардал 837.9 мянга төгрөгөөс 816.7 мянга төгрөгийг, цахим тендерийн үйл ажиллагаанд 525.0 мянга, Урьд оны үлдэгдлээс 9,239.5 мянган төгрөгөөс 1,044. мянга, өвс тэжээлийн орлогоор 37,820.0 мянган төгрөгөөс 30,928.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 23,440.3 мянга, гэрэл цахилгааны зардалд 5,612.6 мянга, цэвэр бохир усны зардалд 1,000.0 мянган төгрөг батлагдсанаас “Эх бүрдэн”ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК, -тай цахилгаанаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянбулаг сумын ЗДТГ нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг  Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 23н-д  бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв  729,008.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,290.1 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,103.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор  2023 оны түлш халаалтын зардлыг 1,819.3 мянга буюу 7.8 %, цэвэр бохир усны зардлыг 530.5 мянга буюу 53.0%-иар хэмнэсэн бөгөөд нийт 2,326.5 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Дараа жилийн төсвийн төсөл, . Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт гэсэн 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж байхыг зөвлөв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар элд хариуцагчийн Бичиг хэргийн тайланд 260.0 мянган төгрөгийн зарлага, Ах ахуйн тайланд 445.0 мянган төгрөгийн тайлан зөрүүтэй байсныг аудитын явцад залруулсан.

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж аудитаар 1,232.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 121,434.9 төгрөгийн 4 албан шаардлага, 4,268.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 78 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 1,389.2 | 1 | 1,232.8 | 100% |
| Албан шаардлага | 4 | 121,434.9 | 4 | 121,434.9 | 100% |
| Зөвлөмж | 3 | 4,268.0 | 3 | 4,268.0 | 100% |
| **Нийт дүн** | **8** | **127,092.1** | **8** | **127,092.1** | **100%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,084.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй авсан 11,084.0 мянган төгрөгийн хөрөнгийг Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан дансаар бүртгэсэн нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, ангилал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 8,843.8 мянган төгрөгийн 1 зөрчил[2] илэрснээс 4,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 4,843.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 8,843.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчлөөс 4,000.0 мянган төгрөгийг материаллаг гэж үзсэн бөгөөд энэ нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,290.1 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Шинэ жилийн баярыг тохиолдуулан бараа үйлчилгээний бусад зардлаас 4,000.0 мянган төгрөгөөр ахмад настан болон байгууллагын шилдэг ажилчдад бэлэг гардуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хууль зөрчиж олгосон 4,000.0 мянган төгрөгийг шийдвэр гаргаж гарын үсэг зуран гүйлгээ хийсэн байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төсөвт буцаан төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

### 5.2 Зөвлөмж[3]

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Бараа үйлчилгээний бусад зардлаас 4 удаагийн уралдаан тэмцээний шагнал урамшууллын зардалд 4,843.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасан “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамд шагнал урамшуулал олгохоор заасан хэдий ч төсвийг тэмцээн уралдааны шагналд хавтгайруулан олгодог байдлыг зогсоох.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

[3] Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зйүлийн 20.5 “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үнэ төлбөргүй авсан 11,084.0 мянган төгрөгийн хөрөнгийг Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан дансаар бүртгэсэн. | 1 | 11,084.0 | | | | | 1 | 11,084.0 | | |
| Дүн | 1 | 11,084.0 | | | | | 1 | 11,084.0 | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шинэ жилийн баярыг тохиолдуулан бараа үйлчилгээний бусад зардлаас 4,000.0 мянган төгрөгөөр ахмад настан болон байгууллагын шилдэг ажилчдад бэлэг гардуулсан байна. | 1 | 4,000.0 | 1 | 4,000.0 | | | | |
| Бараа үйлчилгээний бусад зардлаас 4 удаагийн уралдаан тэмцээний шагнал урамшууллын зардалд 4,843.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 4,843.8 | | | | | 1 | 4,843.8 |
| **Нийт дүн** | **2** | **8,843.8** | **1** | **4,000.0** | | | **1** | **4,843.8** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байхгүй | 0 | 0 | | | 0 | 0 | | |
| Дүн | **0** | **0** | | | **0** | **0** | | |

------------oOo-------------